

Монгол ардын аман зохиол, зан үйл дэхь хувцасны соёлын тухайд

Р.Чүлтэмсүрэн*

1. Оршил

Монголчууд дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил олон төрлийн хувцасны загвар зохион бүтээж, амьдрал ахуйдаа хэрэглэсээр ирсэн. Байгалийн эрс тэс цаг агаар, нүүдэлчин, малчдын аж ахуйн онцлогт тохирсон, жилийн дөрвөн улиралд өмсөх хувцас, эсгий, ноос, арьсан эдлэлээр хувцас хийж ирсэн, чоно, үнэг, тарвага, булга зэрэг ангийн үсээр хувцас хийдэг зэрэг нь бусад зарим орноос ялгагддаг юм. Мөн бөө удган, зайран, буддын шашны лам нарын зан үйлийн болон өдөр тутмын хувцасыг тодорхой бэлгэдэл утгатай, монголын өвөрмөц онцлогт тохируулан бүтээсэн байдаг. Монголын халх, буриаад, дөрвөд, үзэмчин зэрэг олон ястан тус бүрийн үндэсний хувцас тус бүрээсээ ялгагдах онцлогтой байдаг. Мянга есөн зуун хорь, гучаад оноос эхлэн, монголчууд орос, европ хувцас өргөн хэрэглэх болсон юм. Социалист нийгмийн үед монгол дээлийг зөвхөн ахмадууд, малчид, лам нар, бөхчүүд л голлон өмсөж байв. Эмэгтэйчүүд дээлийг гоёл наадамд л өмсөж байсан. Харин албан хаагчид бараг өмсөхөө больсон юм. Тэр байтугай томоохон ресторан, хувьсгалт залуучуудын үдэшлэг зэрэгт монгол дээлтэй хүн оруулдаггүй байв. Харин социалист, коммунист дэглэм задарсан, 1990 оноос хойш нийгмийн бүх давхаргын хүмүүс үндэсний хувцасаа чөлөөтэй хэрэглэх болсон юм.

Монгол хувцасыг эрдэмтэд олон талаас нь багагүй судалсан тул энэхүү илтгэлд зөвхөн монгол ардын аман зохиол, зан үйлд монгол хувцасны үүсэл гарал, хийц загвар, хэрэглэх ёс, бэлгэдэл утга зэрэг хувцасны соёл хэрхэн тусгагдсаныг товч авч үзье.

2. Монгол малгайн түүх, малгай хүндэтгэх ёс журам

2.1 Малгайн үүсэл, бэлгэдлийн тухай домогууд

Монголчууд малгайг их хүндэтгэдэг. Тийм учраас мандах төрийн малгай гэж нэрлэдэг. Малгайн хүндэтгэлийн нэрийг титэм гэдэг. Малгайн бэлгэдэл утгын тухай домог нийт монгол туургатны дунд өргөн тархсан байдаг юм. Түүнээс хоёр домгийг дор өгүүлье.

1) Хилин малгайн учир гэдэг домог

(Зураг 1) Энэ домогт: Хилин ¹⁾малгайн урд тал нь хэрэв урд зүгээс дайсан довтлон ирвэл

* Монгол Улсын Багшийн их сургуулийн багш.

1) Хилин, хилэн гэж малгай дээл мэтийг хийдэг хөвөн мяндас зэргээр нэхэж хийсэн үсэрхэг эд. Хилэн малгай нь зуны гэх мэт улирлын, тайж, түшмэл, лам, өвгөн, эхнэр хүний хилэн малгай, улаан

хамгаалах уул, саад, халхавч болох мэт хэлбэртэй. Хойд тал нь сэтэрхий онгорхой байдаг нь хойд хөрштэйгээ нээлттэй, найрсаг харилцаатай. Малгайны хойд талд улаан бүч²⁾ зүүдэг нь цэвэр ариуны бэлгэдэл утгыг илэрхийлнэ. Яагаад гэвэл монголчууд улаан өнгийг эрхэмлэдэг. Хүнд бэлэг өгөхдөө боодол дээр нь улаан цаас наах юмуу улаан утсаар боодог байжээ. Тэр нь энэ бэлэг цэвэр ариун юм шүү гэсэн утгатай гэнэ. Тэрхүү утгын дагуу улаан бүч хийсэн гэж зарим номонд тайлбарласан байдаг юм.

2) Монгол малгайн домог

Монголд шарын шашныг дэлгэрүүлэн хөгжүүлэгч, монгол соёмбо үсэг зохиогч, соён гэгээрүүлэгч, монголын анхдугаар богд, өндөр гэгээн Занабазар(1635-1723) монгол малгайг зохиосон гэсэн домог бий. Энэ домогт(Зураг 2):

Монгол малгайн чанх урагш харсан тал нь монголын газар нутаг. Малгайн бөмбөгөр оройгоос цацаглан буусан 64 нугалаа оёос(сүүлийн үед 32-оор төлөөлүүлдэг болжээ) бол олон монгол хэлтэн ястны бэлгэдэл. Малгайн орой дээрх сампин³⁾ нь олон ястны эв нэгдлийг илэрхийлнэ. Монгол малгайн хэлбэр сүмбэр уул мэт хэлбэртэй. Эв нэгдлийнхээ хүчинд монгол улс сүмбэр уул мэт бат тогтно. Монгол улс урд талдаа их том хаалгатай. Тэр хаалгаараа урд хөршүүдтэйгээ харьцна. Гэхдээ энэ хаалгаа сайн манаж, сэргийлж байхын тулд хоёр улаан жадыг бэлгэдсэн хоёр улаан бүчтэй байдаг. Монгол улс баруун, зүүн, хойд талаараа бат хэрмээр хамгаалагдсан гэдгийг малгайн хоёр талын хүрээ сөхсөн хоёр чихээр бэлгэдсэн. Монгол улс ар талдаа жижиг хаалгатай. Энэ жижиг хаалгаар гарз гаргахгүйн тулд малгайны ар хэсгийн доод талд хадсан хоёр улаан бүч нь хоёр илдний бэлгэдэл юм. Монгол хүн энэ малгайгаа өмсөж байсан цагт буянаа барахгүй, төр улсаа алдахгүй байж чадна гэсэн (МДЧ, 1999, 20-21) утгыг энэ домогт өгүүлдэг.

2.2 Малгайтай холбоотой зан үйл

Монголчууд малгайгаа хэрэв газар унавал тэр даруй баруун гараараа авч, сэгсрээд, хүндэтгэн үнсэж, дараа нь сая өмсдөг байсан(МҮХС,1997, 162). Энэ заншлыг баталсан жишээ Монголын Нууц Товчооны 245 дугаар зүйлд байна. Үүнд: Тэв тэнгэр Отчигуныг эсрэг заамдан барьж барилдав. Тэв тэнгэрийн малгай барилдахад голомтны(тулганы) ард унав. Мунлиг эцэг малгайг нь авч үнсэж өвөр дээрээ тавив(Цэрэнсодном, 2000, 160) хэмээн дурдсан байдаг. Энэ бол монголчууд малгайгаа хэрхэн хүндэтгэдэг байсны тодорхой жишээ юм.

залаат хилэн малгай гэх мэт олон төрөл ажээ.

- 2) Бүч гэж малгайг салхинд хийсэх, унахаас сэргийлсэн оосор уяа.Төрийн хар хүний малгай улаан бүчтэй, төрийн түшмэл хүрэн, гэгээн хувилгаан хүн шар, ихэс лам нар алаг, хувилгаан хүн хөх, хотын гангацуулын малгайн бүч эрээн өнгөтэй байжээ.
- 3) Малгайн оройн зангилааг сампин гэдэг. Сувдан, улаан шүрэн, цагаан шүрэн сампинтай малгай байжээ. Улаан сампин нь төрийн хар хүний, шар нь лам нарын, шүрэн сампинг гоёлын малгайд хаддаг. Сампингүй малгайг гашуудал илэрхийлэхдээ өмссдөг байжээ.

Мөн Хэрэв унасан малгайн дээгүүр нь хүн алхаж гарсан бол монголчууд заавал галд ариутгасаны дараа өмсдөг. Малгай, бүс бол эр хүний хийморь, эрх сүрийн бэлгэ тэмдэг мөн гэж үздэг(МҮХЗС,1997,162).

Одоо ч гэсэн монголчууд малгайгаа гэдрэг нь буруу харуулан өмсөхийг цээрлэдэг. Оршуулгын зан үйлд талийгаачийн цогцост эхлэн гар хүрэх хүн малгайгаа буруу харуулан өмсөж, дээлнийхээ хормойг бүсэндээ хавчуулан, гар хүрдэг тул тэр бүхнээс үүдэн, малгайгаа буруу харуулж өмсөхийг ихэд цээрлэдэг. Мөн хүн нь нас барсан айлд орохдоо малгайнхаа чихийг буулгаж, дотогш чихэн, малгайгаа буруу харуулан тавих зэргээр гашуудлаа илэрхийлдэг байжээ. Гэтэл одоо залуучууд, элдэв урлагийн хамтлагийнхан малгайгаа буруу харуулан өмсөх нь жирийн үзэгдэл болжээ.

Хуучин цагт төрийн хан, ноёд түшмэдийн малгайг хиа, бараа болооч нь хадгалж, хэзээ ч доор хөсөр тавьдаггүй байжээ. Өдгөө ч гэсэн монголчууд гэрийн эзний малгайг доош тавьдаггүй. Хэн хүн айлд хонох болбол гэрийн эзнээс малгайгаа авах зөвшөөрөл эрдэг. Эс тэгвээс тэр айлыг доромж үзсэн санаархал болдог байна(Дулам, 2002, 106).

Монголчууд айлын гэрт орохдоо малгайгүй толгой нүцгэн орохыг одоо ч цээрлэдэг заншил хэвээр хадгалагдаж байна. Ялангуяа ийм ёс заншлыг хөдөөгийн малчин ардууд, ахмадууд бүр илүү эрхэмлэн сахидаг. Бас айлд ороод тавагтай идээнээс нь амсахдаа толгой нүцгэн байхыг цээрлэнэ. Цагаан сараар хүнтэй золгохдоо заавал малгай өмссөж байж золгоно. Хүнтэй малгайгаа сольж өмсөх их дургүй. Хүний малгайг өмсөх болвол Түй, Минийх биш хүнийх. Өмд биш малгай хэмээн шившлэгийн үг хэлж байж өмсдөг. Алс хол, аян жинд явахад ахмад настай нь бусдыгаа удирдан ахалдаг. Хэрэв хээр гадаа ганцаараа явбал малгай ахалдаг хэмээн үздэг. Аян жинд ганцаар явж байтал цагаан сарын шинийн нэгний өглөө тохиолдвол эхлээд малгайндаа мөргөж, малгайтайгаа золгодог ёс одоо ч байгаа нь малгайг хэрхэн хүндэтгэдэгийн жишээ юм. Мөн хүнд малгайг бэлэг болгон өгдөггүй. Малгай хээр хөдөөнөөс олдвол доошоо харсан сав, бэлгэгүй хэмээн авахыг цээрлэдэг. Бас хүүхэд анх хөлд орж явахыг хармагц аавынх нь малгайгаар цохиж, домнодог ёс ч бий.

Хээр хөдөө гарах, явахыг Малгайн тоос сэргээх гэж хэлдэг өвөрмөц хэллэг бий. Малгай тавибал манайх, маргааш явбал хүнийх гэдэг зүйр үг ч байдаг. Бусдын малгай өмсөв. Ихэсийн малгай өмсөв, төрийн малгай өмсөв хэмээн зүүдлэхийг баяртай сайн зүүд. Өвлийн малгай өмсөв хэмээвэл нэр зэрэг олно хэмээн зүүд тайлах сударт өгүүлсэн байдаг байна.

Малгай гэдэг үгийн гарал нь ...малааныг хаах(халзныг халхлах) гэсэн утгатай. Монгол бөө мөргөлийн гурван сүнсний үзэл ёсоор орой зулайд оршигч оюуны юмуу тэнгэрийн сүнсийг хамгаалах гэсэн утга бэлгэдэлтэй билээ. Тийм ч учраас аливаа зан үйл, ёслол хүндэтгэлийн үед малгайгаа төв тэгш өмсөх, ёслох нь анх гарлаасаа бол оюуны сүнсээ хамгаалж байгаа, сүүлд нь төрийн гүн хүндэтгэлийг илэрхийлж байгаа олон давхар утгатай юм(Дулам, 2002, 106-197).

3. Дээлтэй холбоотой аман зохиол, зан үйл

Монгол дээл бол олон талын үүрэгтэй. Гоёл төдийгүй морь, тэмээ унахад зохимжтой. Хүйтэн сэрүүний улиралд дулаан, биенд хөнгөн. Хээр гадаа хоноглоход хөнжил хучлагын үүрэгтэй ч байдаг. Эртний монголчууд, бөө нар цагаан өнгөтэй дээл өмсдөг байжээ. Цагаан өнгө нь бөө мөргөлийн ёсоор ертөнцийн цагаан зүгийн эздийг урин дуудагч, өлзий бэлгэт өнгө юм. Дундад үеийн монголчууд цагаан сараар хаан, харцгүй цөм цагаан морь унаж, цагаан дээл өмсч, цагаан хадгаар золгодог байжээ. Өдгөө цагийн дархад бөө нэрийн дунд ч гэсэн гэгээн цагаан өнгийн хувцас хунарыг илтэд эрхэмлэн үздэг(Дулам, 2002, 103) байна.

3.1 Дээлтэй холбоотой аман зохиол

Монголчууд хүүхдэд шинэ дээл анх өмсгөхдөө:

Урд хормойг нь

Унага даага гишгиг

Хойд хормойг нь

Хонь хурга гишгиг

Дотоод хормой дээр чинь

Тос өөх наалд

Эд нь хэврэг

Эзэн нь мөнх байг

Энэ жил даалинба

Ирэх жил хоргой торго өмсөг хэмээн шившлэгийн үг хэлдэг. Энэхүү шинэ дээлийг мялаах үг нь өргөн дэлгэр утга агуулгатай. Дээлний эзэн хүүхэд эдээр баян, олон унага, даага, адуутай, олон хурга, ишиг хонь ямаатай, мал сүрэг нь өсөж үржиг. Хоол ундаар элбэг дэлбэг байг. Хүүхэд балчир насандаа даруу төлөв, энгийн эд хувцас хэргэлж, том болоод үнэтэй цайтай хувцас хэргэлэ. Эд хувцасаа гамна. Гэхдээ эзэн нь хувцас хунараасаа урт насал гэсэн агуулгатай бэлгэ дэмбэрэл, ерөөл, шившлэг, мялаалгын үгийн хосолмол шинжтэй. Шинэ дээл өмссөн хүүхэд эх, эцгээс ийм сайхан үг сонсоны дараа айл саахалтын айлаар орж, шинэ дээлээ үзүүлэхэд ахмадууд мөн л дээрх үгийг хэлж, чихэр, мөнгө, ааруул хурууд зэргээр мялаадаг.

3.2 Балжин хатны домог

Буриад монголчуудын дээлний хийц загвар хэрхэн үүссэн тухайг өгүүлсэн Балжин хатны домог гэж байдаг. Балжин хатны домог нь халх, буриад, өвөрлөгч нарын дунд ам болон бичгээр олон хувилбараар өргөн дэлгэрсэн байна. Энэ аман домгийн өгүүлэмж нь Солонгодын⁴⁾ Бүүвэй бэйл, Тай хун тайж гэдэг хүүдээ хол орноос цагаан лусын хааны охин Балжин нэрт бүсгүйг хатан болгон авч өгч байгаагаар өрнөнө. Энэ домог нь Нэгдүгээрт:

Хори буриадын уг гарлын түүхтэй холбоотой байгаа нь,

Хоёрдугаарт: Бүүвэй бэйл Солонгодын хаан, ноён байсан. Солонгууд гэдэг үг орчин цагийн монгол хэлний солонгос гэсэн үгийн олон тоо мөн эсэх, Солонгос үндэстний түүхтэй утгын хувьд холбоотой эсэх,

Гуравдугаарт: Уул домгийн төгсгөлд Бүүвэй бэйл хоёрдахь хатныхаа ховын үг, хар хорон санаанд хуурагдаж, Балжин хатан бэрийнхээ хөх, гар, хөлийг огтолж, толгойг тасдаж, тараан хаяуулсан. Балжин хатныг үе мөчөөр нь салгаж, хороосноос хойш буриад монголчууд Балжин хатнаа дурсан гашуудаж, дээл хийхдээ ханцуй, энгэр зэргийг олон хэсэг эсгэж, дараа нь нийлүүлэн оёдог болсон гэсэн домогтой. Энэ домог хэдийгээр аман зохиол боловч ийнхүү Хори буриадын хаанаас үүссэн угсаа гарал, Буриад монгол, Солонгос үндэстний холбоо хэлхээ, буриад дээлний үүсэл гарлын тухай домог зүйн мэдээ агуулж байгаагаараа угсаатны зүй, аман зохиолын судлалд үнэтэй цэнтэй юм.

3.2 Буриад эмэгтэй дээлний загварыг хэрхэн зохиосон тухай домог

Энэ домогт эмгэн, өвгөн хоёр охиноо хадамд гарах болоход нь эмэгтэй хүний дээл зохиосон тухай өгүүлнэ. (Зураг 3) Эмгэн баруун, зүүн гарынхаа алганы хэсгээр дээлийн баруун, зүүн ханцуйг зохиожээ. Чигчий хуруу буюу богтос талын хэсгээр дээлний ар цээжийг эсгэжээ. Эрхий хурууны уг дээлийн ханцуйны уг буюу мөр хэсэг болжээ. Эрхий хурууны хоёрдахь үеэр түнтгэр мөр буюу ханцуйны бүдүүн хэсгийг, эрхий хурууны нэгдүгээр үеэр ханцуйны нарийн хэсгийг зохиосон байна. Эрхий хурууны хумсны хэсгээр нударгыг тус тус эсгэжээ. Ингэж олон жижиг хэсэг эсгэж, буриад эмэгтэй хүний дээлний загвар зохиосон тухай⁵⁾ энэ домогт өгүүлдэг.

Мөн буриад дээлний ханцуйн уг өргөн байдаг нь нэг удаагийн дайн тулалдааны үед нялх хүүхдээ ханцуйдаа нууж хамгаалж гарсаны бэлгэдэл болгож, тийнхүү хийдэг болсон гэсэн аман домог бас байдаг юм.

3.3 Дээлтэй холбоотой ардын зан үйл

Нялх хүүхдийн дээлийн хүндэтгэлийн нэрийг баривч гэдэг. Шинэ баривч оёод эх нь урдаар өрөөсөн гараа дүрж, эхлэн өмсөж буй байдал гарган, дараа нь хүүхдэдээ өмсүүлдэг ёс бий. Мөн баривчийг гэрийн хаалганы хатавчинд хүргэж, хөдөргөсний дараа өмсгөдөг байсан. Энхрий⁶⁾ эмэгтэй хүүхдэд буруу энгэртэй(солгой энгэртэй), эрэгтэй хүүхдэд авгай

4) Солонгод гэж Солонгос гэдэг үгийн олон тоо. Солонгод овог бол солонгос овог гэж зарим эрдэмтэд үздэг. Ер нь монголчууд Солонгос улсыг таван ондоогор Гууль улс, Гуулин улс, Гаулин улс, Кори улс, Солонгос улс(Дамдинсүрэн,1967,103) гэж түүх судартаа бичсэн байдаг. Мөн Солонгосыг дээр үеэ Гаули улс, Гуулин улс, Кори, Солонгос, Солхо гэж үндсэндээ таван янз нэрлэж ирсэн(Сумьяабаатар) ч гэдэг. Монголчууд Өгөөдэй хааны үеэс Солонгос гэж нэрлэж байсан(Сайшаал). Энэ бүхэн Монголын Нууц Товчоо, Алтан товч, Болор эрхи, Асрагч нэрт түүх, Юан улсын сударт тийнхүү бичсэн байдаг.

5) Чойжилжавын Сонгино, Монголчуудын үйл урлахуйн эрдэм, ухаан, УБ., 1999, 187-188.

6) Айлын ганц хүүхэд юмуу, түрүүчийн үр хүүхэд нь тогтохгүй байсан хүний эрх танхи хүүхдийг энхрий

дээл, тэрлэг хийж өгдөг ёс байв. Тэгэхдээ:

Тоосонд бүү хүр

Тосонд хүр

Хуранд бүү хүр

Хуриманд хүр! гэж бэлгэдэн хэлээд, хойд, урд хормойноос нь гурав гурав дугтраад өмсгөдөг заншилтай. Шөнийн цагаан гэгээ тасрах үед хүүхдэд шинэ хувцас өмсгөдөг аж. Хүүхдэд шинэ хувцас өмсгөхөд эмэгтэйд зүү, утас харин хөвгүүнд эмээлийн жирэм, уурганы хуйв хийх сур өгдөг заншилтай. Хүн нь нас барсан айлд орохдоо дээлийнхээ энгэр, суганы товчоо тайлах, дотогш чихэж өмсөн, уй гашуудлаа тайлдаг. Нас барсан хүний дээлийн захыг уруу харуулах буюу гэрийн үүд рүү чиглүүлэн тавьдаг заншилтай(Батнасан, 1989, 53-54) байжээ.

Хүний хуучин, хөлстэй, хиртэй дээл хувцасыг сольж өмсөхийг цээрлэдэг. Аргагүй өмсөх цаг таарбал Миний дээл биш, хүний дээл гэж шившин нулмиж, цээр гаргаж байж өмсдөг(Дулам, 2002, 105)

Хуучирч муудсан уранхай дээл, нас барсан хүний дээлийг хог дээр хаях болбол захыг нь огтлон авдаг. Дээлний зах дээр гишгэхийг цээрлэнэ. Дээл хийгээд дуусахад үлдсэн шинэ торго, дурдан, хоргой, даавууны өөдсийг хамаагүй бохир газар хаялгүй, галд өргөдөг ёс одоо ч хэвээр мөрдөгдөж байна. Дээлээ бүслэлгүй нөмгөн өмсөх ялангуяа зочин гийчин угтахад нөмгөн дээлтэй байхыг ёс бус хэмээн үздэг юм. Хадамд гарсан бэрд олон зах дээл бэлдэж явуулдаг заншил одоо ч монголын баруун аймгуудад уламжлагдсаар байна.

Алттай дээл өмсөн зүүдэлбээс хан хүнд хүчин нэмэх, цагаан дээл өмсөн зүүдэлбээс сайн бэлгэ үзүүлэн буян хишиг нэмэх, хар дээл өмсч, талд хэвтэж зүүдэлбэл өвчин олох, муу сэтгэлт хүн амь, биед хор хийх, улаан дээл өмсөн зүүдэлбэл үхэх, зовлон болох, эрээн дээл зүүдэлбэл хэл ам учрах, ногоон дээл зүүдэлбэл айх, ариун дээл өмсөн зүүдэлбэл буян ирэх, ариун бус дээл зүүдэлбэл өвчин болох, бусдын дээл өмсөж зүүдэлбэл сайн эм учрах, дээл урагдлаа гэж зүүдэлбэл гэргийн сэтгэл хувирах, сэтгэлийн зовлон маш их болох, төрийн дээл өмслөө гэж зүүдэлбэл сайн хөвгүүн төрөх, охор богино дээл өмсч зүүдэлбэл үгүйрэх, их гамшиг болох, дээл буруу өсч зүүдэлбэл мал идээ хомс болох, дээл галд түлэгдлээ гэж зүүдэлбэл биед өвчин хүрэх гэх мэтээр зүүдийг тайлдаг байна.

4. Бүстэй холбоотой зан үйл, аман зохиол

4.1 Бүстэй холбоотой ардын зан үйл

Монголчууд эрт дээр үед суран бүс бүсэлдэг байсан нь хадны сүг зураг, архелогийн судалгаагаар нотлогджээ.

Бүс бол задарсан, сарнисан бүхнийг эвлүүлж, бэхэлж өгдөг гэсэн бэлгэдэл утгатай.(Зураг

хүүхэд гэдэг.

4) Бүс⁷⁾ саадаг хоромсогоо агсах, илд сэлэм, хэт хутга, хөөрөг даалинбаа зүүх үүрэгтэйгээс гадна морь унаж, ажил хийж, явган явахад дээл хөлөөр орооцолдохгүй, биеийн хэлбэр галбирыг тодруулсан гоёлын хэлбэртэй, гэдэс дотор, бөөрийг даарах, доргихоос сэргийлэн хамгаалж байдаг.(Эртний монголчууд анд нөхөр бололцохдоо бүсээ харилцан солилцдог байжээ.

Монголын Нууц Товчооны 116, 117 дугаар зүйлд: Тэмүжин, Жамух хоёр Хорхонаг Жубур гэдэг газар эртний анд бололцсоноо дурдалцан, андаа сэргээж, амраглахдаа харилцан алтан бүсээ солилцон бүсэлдэг(Цэрэнсодном, 2000, 64).

Бүс солилцон анд болох, андалдах ёс эртнээс уламжилж иржээ. Хэрэв хэн нэг хүн ял хийвэл малгай бүсийг нь хураан авдаг байжээ. Тухайлбал: Монголын Нууц Товчооны 244 дүгээр зүйлд: Тэв тэнгэр гэдэг бөө Чингис хаанд хандан, Мөнх тэнгэрээс нэг үе Тэмүжин(Чингис) хаан болно. Нэг үе Тэмүжины дүү Хасар хаан болно хэмээн хэллээ гэнэ. Тэгэхэд Тэмүжин шөнө явж, Хасарыг бариад дээлнийх нь хоёр ханцуйг уяж, малгай, бүсийг нь авч, хороох гэнэ. Үүнийг Тэмүжины эх мэдээд яаран очиж, уурлан зэмлэж, Хасарын уясан ханцуйг тайлж, малгай, бүсийг нь Хасарт өгч, сургамжлан хэлэхэд Тэмүжин их ичиж байгаа тухай(Цэрэнсодном, 2000, 158) өгүүлдэг. Эндээс алах болон ял эдлүүлэх хүний малгай, бүсийг эн тэргүүнд хураан авч, сүр сүлдийг нь мохоодог байсан ёс байсныг харуулж байна. Тэмүжинг эх нь буруутгаж, Хасарыг өмөөрөхдөө мөн эн тэргүүнд малгай, бүсийг нь буцаан өгч, сүр сүлдийг нь сэргээж байдаг. Мөн Чингис хаан бүсээ тайлж, хүзүүндээ тохож байгаад Бурхан Халдун ууланд мөргөж тахиж байсан гэдэг. Ер нь Монгол хүний сүлд хийморь, буян заяа бүсэндээ явдаг тул сүнс зайлахад бүсээрээ дуудах, буян хишгээ бүсээрээ далладаг байжээ. Иймээс бүсэн дээгүүр алхах, хөл хүргэх, хүнд хэрэглүүлэхийг хатуу цээрлэдэг. Мөн шөнө унтахдаа очир, үнэгэн чих зангидан дэрэн дороо хийх юмуу уундаа хавчуулдаг заншилтай. Очир хүний буян хишиг зайлах, гарлагын үүдийг хаадаг. Үнэг унтаж байсан ч соргог хэвээрээ чих нь хөдөлж байдаг тул хүн хийморьтой явахын тулд сонор срогог байх ёстой(Сонгино, 1999, 224) гэдэг утгаар тийнхүү бүсээ зангиддаг байна. Эрдэмтэн С.Дулам⁸⁾ бас ийм зан үйл байдгийг тэмдэглэжээ.

Бүсийг өсөх төрийн бүс хэмээн хүндэтгэж,

Нөхрөө харж биеэ

Сүүдэрээ харж бүсээ зас гэсэн зүйр цэцэн үгнээс харахад ч бүсийг хичнээн их эрхэмлэдэг нь тодорхой.

7) Орчин үеийн монгол дээлний бүс дээлнийхээ өнгөтэй ойролцоо юмуу тод шар өнгөтэй голдуу байдаг. Эрэгтэй хүний бүс 10 см-ээс илүүгүй өргөн, 150 см урт, эмэгтэйнх 6 см-ээс өргөнгүй, 130 см урт байдаг.

8) Монголчууд бүсийг бүтэх төрийн бүс хэмээн төр ёсны бэлгэдэл болгох бөгөөд эр хүний хийморь бүсэндээ явдаг хэмээн үздэг тул бүсийг доор тавих, дээр нь гишгэлэхийг хатуу цээрлэдэг. Монгол бөө мөргөлд сүлд нь зайлсан хүний сүлдийг дуудахдаа бүсээр нь хурайлдаг. Монголчууд өдгөө хүртэл унтахдаа бүсээ очир зангилгаагаар эвхэн дэрэн дээрээ тавьж дээдэлдэг. Зүүдээ манахын тулд...долоогийн тоог эрхэмлэн долоо нугалж(зангидаж), дундуур нь нэг зангидан очир зангилаа мэт болгон дэрлэдэг байсан болов уу(С.Дулам,2002,108) гэжээ.

4.2 Бүстэй холбоотой аман зохиол

1) Бүсийг огтолдоггүйн учир хэмээх аман домогт:

Нэг хүү эх эцгийнхээ үгэнд оролгүй ураг хуриманд очоод хорон сэтгэлт зурхайчид хорлогдож үхнэ. Хүү үхэхийн өмнө: Бүсийг минь огтлон, толгойг минь ороогтун гээд нас барна. Түүнээс хойш эр хүний бүсэнд сүнс нь явдаг тул бүсийг огтлохоо больж, орой унтахдаа бүсээ зангидаж тавьдаг болжээ⁹⁾ гэж өгүүлдэг.

2) Мянгад эмэгтэй хутга бүсэндээ зүүдэг тухай домогт:

Монгол эрэгтэй хүн л бүсэндээ хутга зүүдэг. Эмэгтэй хүн хутга зүүдэггүй. Харин монголын мянгад эмэгтэй хүн дээр үед бүсэндээ хутга зүүдэг байжээ. Энэ нь эрт цагт Дөрвөд далай хан нэг хэсэг овгийнхныг мянган цэрэг гарга гэжээ. Гэтэл эрчүүл нь 1000 хүрэхгүй болохоор бүсгүй хүнд хутга зүүлгэж, эрийн дансанд тоолж байж, мянга хүргэсэн тул тэднийг Мянгад гэх болжээ. Энэ үеэс эхлэн мянгадад эхнэр болоогүй бүсгүйцүүл эрэгтэйчүүдийн адил хутга зүүдэг заншилтай болсон ажээ¹⁰⁾ гэж өгүүлдэг.

Монголчууд ариун бүс бүсэлж зүүдэлбэл эд таваар дэлгэрэн арвижих, алтан, мөнгөн бүс бүсэлж зүүдэлбэл баяжих, бүс алдуурвал зовлон арилна гэх мэт зүүдийг тайлан шинждэг байна.

5. Эхнэр үс үүссэн тухай домог

Халх монгол эхнэр хүний хувцасны гоёл, сүрлэг сайхан үзэмж, өнгө хэлбэрийн зохицол нь монгол хувцасны хөгжилт, загварт шинэчлэл өөрчлөлт болжээ. Халх эхнэрийн хувцасны дизайнд эхнэр үс нь гол чимэг, донж болдог санагддаг юм.(Зураг 5) Энэхүү эхнэр үсийг анх сэдсэн, үүсгэсэн тухай ардын аман домгууд уламжлагдаж ирсэн. Тийм гурван домгоос нэг хувилбарыг танилцуулъя. Манж нар монгол тулганы эцэг, эх, хүү, бэр гэсэн утгатай дөрвөн тотгыг дөрвөн хар хэрээний хошуугаар дүрслэн хийж, Халх монголын гал голомтыг дөрвөн хэрээгээр ухуулж, сөнөөнө гэсэн утгатай хийжээ. Үүнийг нь монголчууд мэдээд хар хэрээ юунаас айдаг болохыг бодон олжээ. Хар хэрээ хамаг жигүүртний хаан Хангарьд¹¹⁾ шувуунаас айна гээд галын дэргэд үргэлж байдаг эмэгтэйчүүдээ Хангарьдын дүрээр хувцаслан, үсийг нь хагалан самнаж, ган хайч баруулан, галын дэргэд суулгажээ. Ган хайч барьдагийн учир нь гал голомтоо хэрээнд ухуулахгүй үргэлж хэрээний хошууг хайчаараа тас цохин зайлуулж байх утгатай ажээ(Сонгино, 1999, 187).

Ийнхүү эхнэр хүн үсээ Хангарьдын далавч шиг дэрэвгэр болгон сүлжиж байснаа сүүлдээ

9) Мандах, Хасчимэг, Монголын зан аалийн үлгэр, ӨМСХХХ, 1997, 115-116

10) Монгол домог, 4.Мянгадын тухай, Эмхтгэн боловсруулж удиртгал, тайлбар бичсэн Х.Сампилдэндэв, БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын Хүрээлэн, УБ., 1984, 42

11) Монгол аман зохиолын болон буддийн домгийн дүр.;Монголд: Хангарди, Буриадад: Хан хэрдиг, Халимагт: Хэрд хэмээн нэрлэдэг. Нэрийн гарлын хувьд эртний Энэтхэгийн вээдийн домгоос гаралтай. Домгийн хүчирхэг шувуу. Монгол домогт голдуу шувуудын хаан гэж гардаг(С.Дулам, Монгол домог зүй, УБ., 1989, 178).